

1. Иргэний болон эрүүгийн гэмт хэрэг гарсан тохиолдолд хүний эрхийг хамгаалах

Солонгост амьдрах явцад олон янзын хэрэг төвөг гарах нь мэдээж. Хувь хүмүүс хоорондын мөнгөний наймааны асуудал гарах ч юм уу, зарим тохиолдолд гэмт хэрэгтэй холбогдон цагдаагийн газарт баригдан очих нь ч бий. Мөн иймэрхүү асуудалаас болж иргэний зарга болон эрүүгийн зарга үүсгэх үе ч бий. Солонгосын хууль ийм тохиолдолд ёс горимыг чандлан сахихын зэрэгцээ холбогдох этгээдүүдийн хүний эрх халдагдахгүйгээр тогтоогдсон байдаг. Иргэний хэрэг, эрүүгийн хэрэг гарсан тохиолдолд үйлчилдэг хуулийн ёс горим болон хүний эрхийг хамгаалах тогтоолын талаар доор тайлбарласан болно. Сайн уншиж үзээд хохирол амсахгүйгээр асуудалаа шийдэх хэрэгтэй.

1. Иргэний/Эрүүгийн хэрэг болон хүний эрхийн хамгаалалт

◆ Иргэний хэрэг гэж хүмүүс хоорондын ойлголцолын харилцаа зөрөөтэйн улмаас асуудал үүссэн хэдий ч харилцан зөвшилцөлд хүрч чадаагүйгээс улсын байгууллага болох хуулийн газар асуудалыг зохицуулан, шийдвэрлэхийг хэлнэ.

◆ Маш олон төрлийн асуудал гардаг бөгөөд цалин, осол юм уу зодуулахтай холбогдсон эмчилгээний төлбөр, түүний нөхөн төлбөр, орон сууцны барьцааны мөнгө гэх мэт мөнгөтэй шууд холбоотой асуудал байхын зэрэгцээ ажлаас халагдах, үр хүүхэд болон гэрлэлт гэх мэт мөнгөтэй шууд холбоогүй асуудалууд ч бас бий.

◆ Эрүүгийн хэрэг гэж аливаа улс нийгмийн дэг журмыг сахиулах үүднээс ийм ийм төрлийн нийгмийн үйлдэлийг хийж болохгүй гэж хууль дурмээр тогтоон үүнийг зөрчсөн тохиолдолд шийтгэл оногдуулдаг хэргийг хэлнэ.

1-1. Эрүүгийн мөрдөн байцаалтанд орох тохиолдолд(хён-са сү-са)

1-1-1. Эрүүгийн мөрдөн байцаалтын шат дамжлага

◆ Мөрдөн байцаалт: Нийгэмд гарсан тухайн нэг үйлдэл гэмт хэрэгт тооцогдох эсэхийг ялгаж зааглахын тулд эрүүгийн хэргийг судлахыг эрүүгийн мөрдөн байцаалт гэнэ.

◆ Шүүхийн шийдвэрийг газар дээр нь гаргах(жөг-гёл шим-пан): Шүүхийн шийдвэрийг газар дээр нь гаргах гэж хөнгөн эрүүгийн хэрэгт товч, шуурхай шат дараагаар шийтгэл оноодог системийг хэлнэ. Шүүхийн шийдвэрийг газар дээр нь гаргах үйл ажиллагаа цагдаагийн газрын дарга шүүгчээс шаардсан тохиолдолд явагддаг. Шүүхийн шийдвэрийг газар дээр нь гаргах үйл ажиллагаа ерөнхийдөө хорих(гү-рю), торгуул ноогдуулах(гуа-рю/бол-гөм) хэлбэрийн ялыг оноодог бөгөөд үүнийг биелүүлэхээс татгалзсан яллагдагч ялын шийдвэр гарснаас хойш нэг долоо хоногийн дотор албан ёсны шүүх ажиллагаа явуулахыг шаардаж болно.

◆ Гэм буруутай болох нь тогтоогдох(иб-гон): Гэм буруутай болох нь тогтоогдох гэж мөрдөх байгууллага мөрдөн байцаалтыг явуулж байгаад эрүүгийн хэрэг болохыг олж тогтоохыг хэлнэ. Гэм буруутай болох нь тогтоогдвол эрүүгийн хуулийн дагуу сэжигтэн(пи-ы-жа) болно.

◆ Баривчилах(че–пу): Гэм буруутай болох нь тогтоогдсон сэжигтэн гэмт хэрэг үйлдэх сэжиг төрүүлэх, хүндэтгэх шалтгаангүйгээр мөрдөн байцаалтын газрын хүрч ир гэсэн шаардлагыг хүлээж авахгүй байх, аль эсвэл тухайн шаардлагыг огт хүлээж авахгүй байж болзошгүй үед баривчилна. Сэжигтэнийг баривчилахын тулд шүүгчийн баривчилах тушаал(ён–жан) байх ёстой. Гэхдээ яаралтай шаардлага гарах юм уу хүнд гэмт хэрэг болох, үргэлжилсээр байгаа гэмт хэрэг болох нь тогтоогдвол баривчилах тушаалгүйгээр баривчилгааг шуурхайлан явуулж болно. Харин сэжигтэнийг баривчилсан даруйдаа прокуророор хүлээн зөвшөөрүүлэх ёстой.

◆ Хорионд хийх(гү–суг): Мөрдөн байцаалтын үр дүнд хүнд гэмт хэрэг болох нь тогтоогдох, зугатах аль эсвэл баримт нотолгоог устгах магадлалтай үед сэжигтэнийг хорионд хийнэ. Хорионд хийхийн тулд шүүгчийн "хорионд хийх тушаал" байх ёстой. Баривчилсан болон яаралтай баривчилсан сэжигтэнийг хорионд хийх үедээ баривчилсанаас хойш 48 цагийн дотор шүүгчид хандан "хорионд хийх тушаал" гаргаж өгөхийг шаардах ёстой. "Хорионд хийх тушаал гаргах" шаардлагыг тавихгүй байх юм уу, аль эсвэл уг тушаалыг авч чадаагүй үедээ сэжигтэнийг даруй суллах ёстой.

◆ Хэргийг шилжүүлэх(сун–чи): Эрүүгийн гэмт хэрэгтэй холбогдсон мөрдөн байцаалтыг дуусгах эрх зөвхөн прокурорт л байдаг. Тиймээс шүүхийн цагдаа сэжигтэнийг хорионд хийсэн бол түүний хэрэг Прокурорын газарт шилжигдэнэ гэсэн үг.

◆ Шүүхийн байгууллагаас шүүх үйл ажиллагаа явуулахыг шаардах(ги–су): Шүүхийн байгууллагаас шүүх үйл ажиллагаа явуулахыг шаардах гэж шилжин ирсэн хэрэг юм уу биечилэн мөрдөн

байцаасан хэргийн сэжигтэн шүүгдэх ёстой болох нь тогтоогдсоноор шүүхийн газарт шилжигдэхийг хэлнэ. Энэ шатнаас эхлэж сэжигтэнийг гэмт этгээд(пи-гу-ин) гэнэ. Шүүхийн байгууллагаас шүүх үйл ажиллагаа явуулахыг шаардах нь товч(яг-шиг ги-су), буцааж авах(бүл ги-су), хорих(гү-суг ги-су) гэсэн хэлбэрүүдтэй. Яг-шиг ги-су нь шүүхийн байгууллагаас шүүх үйл ажиллагаа явуулахыг шаардахын хамт торгуулийн хэлбэрийн шийтгэл оногдуулахыг хүсдэг хэлбэр болно. Энэ утгаараа товч тушаал гаргахыг шаарддаг хэлбэр юм. Бүл ги-су нь прокурор хэргийг шүүхэд шилжүүлэхээ болихыг хэлнэ.

◆ Шүүх үйл ажиллагаа(жэ-пан): Прокурорын шүүх үйл ажиллагаа явуулахыг шаардсан хэргийн тухайд шүүхийн байгууллагаас шүүх ажиллагаа явуулна. Шүүх ажиллагаа нь шүүхийн байгууллага дотор байдаг шүүх ажиллагааны танхимд нээлттэй явагдана.

◆ Шүүхийн шийдвэр(пан-гёл): Шүүгч хэргийг судлан үзсэний үр дүнд гэм буруутай болох нь нотлогдвол үүний үндсэн дээр ял заах юм уу ялын шийдвэр хэрэгжүүлэхээ хойшлуулах, аль эсвэл ялын тогтоол гаргахаа хойшлуулах болохоо мэдэгдэнэ.

◆ Ял эдлүүлэх: Шүүх байгууллагын шийдвэр дээр үндэслэн заагдсан ялын тогтоол нь прокурорын удирдлагаар гүйцэтгэгдэнэ. Хоригдох ялыг шорон(гюу-ду-су)-д эдлэх бөгөөд торгуулийг шүүхийн шийдвэр гарснаас хойш 30 хоногийн дотор төлж барагдуулах ёстой.

1-1-2. Эрүүгийн мөрдөн байцаалтын явц дахь хүний эрхийн хамгаалалт

◆ Хорионд орохын өмнө сэжигтэнийг байцаах систем: Гэмт хэрэгт

сэжиглэгдсэний улмаас хорионд орох тушаал авсан сэжигтэн нь хорионд орохынхоо өмнө байцаалт өгөх өргөдөл гаргаж болно. Энэ систем нь хорионд орох эсэхийн талаар шийдвэр гарахаас өмнө шүүгчийн урд өөрийгөө тайлбарлах бололцоо олгодог системийг хэлнэ. Хорионд орохын өмнө сэжигтэний байцаах систем нь сэжигтэн өөрөө өргөдөл гаргаж болохын зэрэгцээ сэжигтэний өмгөөлөгч, хуулийн төлөөлөгч, гэр бүл юм уу хамтран амьдрагч нь өргөдөл гаргахыг хүлээн зөвшөөрдөг болно. Харин сэжигтэн өргөдөл гаргасан гээд заавал тэр өргөдлийг нь хүлээж авна гэсэн баталгаа байхгүй.

◆ Хорионд хийх үйл явц хуулинд нийцэж байгаа эсэхийг шалгах систем(жог–бу шим–са–же): Баривчилах тушаалын дагуу мөрдөн байцаах байгууллагад баривчлагдсан болон хоригдсон сэжигтэн нь шүүхийн байгууллагаас тухайн баривчилгаа болон хорио зүйд нийцэж байгаа эсэхийг шалгаж өгөхийг шаардаж болно. Хорионд хийх үйл явц хуулинд нийцэж байгаа эсэхийг шалгах талаархи өргөдлийг сэжигтэн өөрөө юм уу сэжигтэний өмгөөлөгч, гэр бүл юм уу хамтран амьдрагч нь гаргаж болно.

◆ Батлан даалтанд гарах(бу–сог) : Хоригдох ял заагдсан гэмт хэрэгтэн хариуцсан шүүхийн байгууллагаасаа батлан даалтын мөнгө төлөх нөхцөлөөр чөлөөлж өгөхийг шаардаж болно. Батлан даалтанд гарах өргөдөлийг гэмт этгээд өөрөө юм уу гэмт этгээдийн өмгөөлөгч, гэр бүл, хамтран амьдрагч нь гаргаж болно

◆ Шүүхийн нөхөн төлбөр(хён–са бу–сан) : Хоригдож байх хугацаанд нь гэм буруугүй болохыг нь тогтоосон шүүхийн шийдвэр гарсан, аль эсвэл прокурор нь шүүхийн байгууллагад тавьсан шүүх ажиллагааны шаардлагаа эргүүлэн татсан(бүл–ги ги–су) хүмүүсийн дотроос гэм

буруугүй болох нь илэрхий болсон хүнд шүүхийн нөхөн төлбөрийн хуулийн дагуу хоригдсоны төлөөхи нөхөн төлбөр олгоно.

1-2. Цагдаад баригдсан үедээ анхаарах зүйлс

◆ Мирандагийн зарчим: Цагдаа сэжигтэнийг баривчлах үед сэжигтэнд, "сэжигтэн баривчилгааны учир шалтгаан болон хорионд хийх болсны учир шалтгааныг мэдэх, өмгөөлөгчийн туслалцаа авах, өөрт хохиролтой гэрчийн мэдүүлэгээс татгалзах эрхтэйг заадаг" Миранда зарчимийг сануулах хэрэгтэй. Хэрэв цагдаа Миранда зарчимийг сануулаагүй бол өмгөөлөгч юм уу прокурорын байцаалт, судалгааны явцад энэ талаар дурьдах ёстой.

◆ Цагдаагийн газар хүргэгдсэн тохиолдолд байцаалтын протокол(шин–мүн жу–со) хөтлөнө. Сэжигтэний байцаалтын протокол нь өөрийгөө илчлэх чухал нотолгоог хадгалсан баримт болдог тул мэдүүлэг өгөхдөө тун болгоомтой байх шаардлагатай. Ялангуяа прокурорын газарт хийгдсэн сэжигтэний байцаалтын протоколыг сүүлд шүүхийн байгууллага дээр очоод үгүйсгэсэн ч нэмэргүй байдаг. Зарим тохиолдолд прокурорын газарт гэмт хэрэгт сэжигтэй болохоо хүлээн зөвшөөрвөл ялын хэмжээг багасна гэсэн үгэнд итгэн гэмт хэргийг хүлээн зөвшөөрч байгаад шүүхийн байгууллага дээр очсон хойноо түүнийгээ үгүйсгэх явдал гардаг бөгөөд энэ тохиолдолд бүр илүү таагүй байдалд орж ч болно.

◆ Цагдаагийн байцаалтанд дуугүй өнгөрөх эрхтэй бөгөөд цагдаагийн хөтөлсөн протокол өөрийн чинь үгтэй зөрөх магадлал байдаг тул ойлгохгүй байгаа зүйлийн дор гарын үсэг зур гэсэн ч зурж болохгүй. Өмгөөлөгч ирэх хүртэл дуугай байж байгаад өмгөөлөгчтэйгээ

зөвшилцсөний үндсэн дээр байцаалтанд хариулж болно.

◆ Цагдаа солонгос хэл сайн мэдэхгүй гадаадын иргэнээс байцаалт авахдаа орчуулагчийн туслалцаа авах шаардлагатай. Цагдаагийн газар баривчлагдан очиж, байцаалтанд орох үедээ орчуулагч олж өгөхийг шаардах, дэмжлэг үзүүлдэг байгууллага юм уу өмгөөлөгчтэйгээ холбоо барьж өмгөөлөгч дуудах нь зохистой.

◆ Гэмт хэргийн сэжигтэнээр цагдаагийн газарт баригдсан байх үедээ цагдаад зодуулах юм уу тулган хүлээлгэх, заналхийлэх, нойргүй хонуулан мөрдөн байцаалт авах, бэлгийн харьцаанд уруу татах, хүчиндэх зэргээр цагдаагийн хатуу ширүүн үйлдэлд өртвөл дэмжлэг үзүүлдэг байгууллага юм уу өмгөөлөгчтэйгээ холбоо барих шаардлагатай. Цагдаагийн хатуу ширүүн үйлдэлийг хуулиар хориглосон болно.

◆ Баривчлагдах явцдаа гэмтэх, гав, бороохой, цахилгаан цохигч зэрэг цагдаагийн хэрэгсэлийн нөлөөгөөр гэмтэсний улмаас эмчилгээ авах шаардлагатай болвол эмч дуудаж өгөхийг шаардах ёстой. Мөн бие өвдсөн үедээ эмчилгээ хийлгүүлэх бололцоо олгохыг хүсэх эрхтэй.

◆ Дүрвэх/цагаачлах юм уу орогнохыг хүссэн өргөдөл гаргасан үедээ баривчлагдвал хариуцсан цагдаадаа энэ талаар мэдэгдэн НҮБ-ийн цагаач иргэдийн хэрэг эрхэлсэн газар юм уу Цагаач иргэдийг дэмжих байгууллагатай холбоо тогтоож өгөхийг хүсэх хэрэгтэй.

◆ Байцаалт дуусвал байцаалтын протоколд гарын үсэг зурах болдог. Энэ үед байцаалтын протоколыг нэгд нэггүй уншиж байж гарын үсгээ

зурах ёстой. Өөрт ашигтай мэдээлэл ном ёсоор тэмдэглэгдсэн эсэх, өөрийн хэлээгүй үг бичигдсэн эсэхийг авч үзнэ. Хэрэв цагдаа айлган сүрдүүлэнгээ гарын үсэг зурахыг шаардвал татгалзах хэрэгтэй. Гарын үсэг зурагдаагүй сэжигтэний байцаалтын протоколыг баримт нотолгоо болгон хэрэглэдэггүй бөгөөд үнэнд нийцэхгүйгээр тэмдэглэсэн мэдээлэл байвал засч өгөхийг шаардана. Гэсэн ч засахгүй байвал гарын үсэг зурахаас татгалзах хэрэгтэй.

1-3. Эрүүгийн гэмт хэргийг шүүх ажиллагааны дэг журам

◆ Эрүүгийн гэмт хэргийн шүүх ажиллагаа нь 3 шат дамжлагатайгаар явагдана.

◆ Анхан шатны шүүхийн үр дүнд гэмт этгээд юм уу прокурорын зүгээс "түтгэлзэл" байвал анхан шатны шүүхийн шийдвэр гарсны дараа долоо хоногийн дотор 2 дахь шатны шүүх болох орон нутгийн шүүхэд (яаралтай) давж заалдаж болно.

◆ Давж заалдасны дагуу орон нутгийн шүүхээс дахин шүүхийн шийдвэр гаргасан ч "түтгэлзэвэл" гэмт этгээд юм уу прокурор нь 2 дахь шатны шүүхийн шийдвэр гарснаас хойш долоо хоногийн дотор 3 дахь шатны шүүх болох Дээд шүүхэд (яаралтай) давж заалдана.

◆ Дээд шүүхэд давж заалдах нь анхан болон 2 дахь шатны шүүхээс ялгаатайгаар гэмт этгээд шүүх хуралдааны танхимд очилгүй бичиг баримтаар дамжуулан явагдах тохиолдол ч бий.

◆ Дээд шүүхэд давж заалдасны дараа ялын эцсийн шийдвэр гарна. Анхан шатны шүүх юм уу орон нутгийн шүүхийн шийдвэрийг давж

заалдахгүй бол ял батлагдана. Ял тогтоогдвол гэмт этгээд нь шоронд орж, ялаа эдлэнэ.

1-4. Хорих байгууламжинд хоригдсон үедээ

Солонгосын хорих байгууламж нь цагдаагийн газрын дотор байрладаг түр саатуулах газар(юү–чи–жан), камер(гү–чи–су), шорон(гюү–ду–су) зэрэг болно. Гадаадын иргэд албан хүчээр эх орондоо буцах хүртэлээ "гадаадын иргэдийг хамгаалах газар"-т байрладаг. Хорих байгууламж нь хүчээр хууль хэрэгжүүлэх арга хэмжээ хүчтэй авч явагддаг газар болно. Мөн амьдрах орчины хувьд ч тааруухан байдаг. Үүнтэй уялдан хорих байгууламжид хүний эрх олон янзаар зөрчигдөх нь бий. Хэдийгээр хууль зөрчин хоригдож байгаа хэдий ч хүний эрх хамгийн наад захын төвшинд хамгаалагдах ёстой.

1-4-1. Цагдаагийн түр саатуулагдах газарт хоригдох үедээ

◆ Түр саатуулагдах газар: Цагдаагийн түр саатуулагдах газар нь шуурхай шүүхийн шийдвэрээр түр хоригдох тушаал авсан юм уу түр саатуулагдах тушаал авсан үед саатуулагддаг газар болно. Басхүү сэжигтэн гэмт хэрэгт сэжиглэгдэн баривчлагдаад, хэрэг нь прокурорын газар руу шилжигдэх хүртэлээ энд түр саатуулагдах нь тохиолдол ч бий.

◆ Түр саатуулах газарт хоригдсон хүний эрх хамгаалагдана.

◆ Цагдаагийн тамлах юм уу хатуу хэрцгий үйлдэл хийхийг мэдсэн хэрнээ мэдээгүй дүр эсгэж болохгүй. Тиймээс хэрэв зээ цагдаа хоригдогчтой харгис хэрцгийгээр хандахыг харсан бол тэр даруй өмгөөлөгч юм уу дэмжлэг үзүүлдэг байгууллагатай холбоо барих

хэрэгтэй.

◆ Түр саатуулагдах газарт хоригдохын өмнө сэжиглэгдэгч хамрагддаг биеийн нэгжлэг дотроос нүцгэн биеийн нэгжлэг нь хамгийн сүүлд явагдах ёстой. Нүцгэн биеийн нэгжлэг хийх үед ч хүний эрхийн халдлага байхгүй байх ёстой. Тиймээс биеийн нэгжлэг хийх үед ноцтойгоор доромжлуулах юм уу ичгүүртэй байдалд орсон бол энэ талаар өмгөөлөгч юм уу дэмжлэг үзүүлдэг байгууллагад мэдэгдэн алдааг нь засуулах хэрэгтэй.

◆ Хэрэв бие чинь өвдсөнөөс эмчийн үзлэг зайлшгүй хэрэгтэй болвол эмч дуудаж өгөхийг шаардаж болно.

◆ Эмэгтэй хүний тухайд эмэгтэй эмчээс эмчилгээ авах эрхтэй бөгөөд жирэмсэн эмэгтэй шаардлагатай бол төрөхөөс өмнөх, төрсний дараахи бүх төрлийн эмчилгээ, арга хэмжээнд хамрагдах эрхтэй.

1-4--2. Камер юм уу шоронд хоригдсон үедээ

◆ Камер нь гэмт хэрэгт сэжиглэгдэн баривчлах тушаал гарсан сэжигтэн шүүгдээд, ял заагдах хүртлээ хоригддог газрыг хэлнэ. Сэжигтэн камерт байх явцдаа прокурорын байцаалтанд орох бөгөөд шүүхийн байгууллага руу шилжигдэх эсэхээ хүлээдэг. Ингэх хүртэл шаардагддаг хамгийн дээд хугацаа нь 20 хоног болно.

◆ Шорон бол гэмт хэргийн талаарх ял нь тогтоогдсоноор ялаа эдэлдэг газар болно. Гадаад иргэдийн тохиолдолд шоронд бүх ялаа эдэлж дууссаны дараа Кёнг–ги аймгийн Хуасон–д байдаг гадаад иргэдийг хамгаалах газарт хүргэгдэн, тэндээсээ хүчээр эх орон руугаа буцна.

◆ Камер юм уу шоронд хүч хэрэглэх, хууль дүрэм зөрчигсдөд оногддог шийтгэл, эрүүл мэндийн асуудал, гадны хүнтэй холбоо харилцаатай байх, ялгаварлан гадуурхах зэрэгтэй уялдан хүний эрх хөндөгдөх асуудалууд гардаг.

◆ Биеийн хүчийг ашиглах: Хорих байгууламжийн харгалзагч нар хоригдолууд оргох, зодолдох, амиа хорлох зэргийг хаах, таслан зогсоох үүднээс шаардлагатай үед зэвсэг, хүч хэрэглэх эрхтэй. Гэхдээ тэр эрхээ хамгийн доод төвшинд эдлэх ёстой. Энэ эрхээ хүний ёсны бус хэлбэрээр юм уу хэт урт хугацаагаар эдлэхийг хүний эрхэнд халдаж байна гэж үздэг. Хүч хэрэглэх болон зэвсэг хэрэглэх үедээ зарчмын дагуу урьдчилан сануулга өгсний дараа хэрэглэнэ.

◆ Заримдаа хоригдолуудын хооронд үүссэн зодооны улмаас хохирол амсах нь ч бий. Хорих байгууламжийн харгалзагч нь хоригдолуудын зодооноос урьдчилан сэргийлэх үүднээс шаардлагатай арга хэмжээг авах үүрэгтэй. Тиймээс хэрэв урьд нь зодуулж байсан хоригдолдоо дахин зодуулах магадлал байх юм уу, урьд өмнө нь зодуулж байсан удаатай бол энэ тухай харгалзагчдаа мэдэгдэн арга хэмжээ авч өгөхийг шаардах ёстой.

◆ Харгалзагчийн зааврыг зөрчсөн ч харгалзагч хоригдолыг зодож болохгүй.

◆ Шийтгэл(жин–бол): Хоригдол хууль дүрэм зөрчсөн үед хорих байгууламжийн харгалзагч шийтгэл өгөх эрхтэй байдаг. Гэхдээ шийтгэл нь шүүхийн зарчмын дагуу оногдох бөгөөд шийтгэлийн ёс журам шударгаар явагдах ёстой. Мөн шийтгэл хэрэгжүүлэлт хэт харгис хэрцгий явагдах юм уу шүүхийн зарчимаас ангид явагдаж

болохгүй.

◆ Хорих байгууламжийн амьдрах орчин таарууханы дээр хоолны хэмжээ нь хангалуун биш байдгаас өвчин тусах магадлал өндөр. Хорих байгууламжид амьдрах хугацаанд өвчин тусах юм уу урьдны өвчин нь сэдэрснээс эмчийн эмчилгээ хэрэгтэй болох үед харгалзагчдаа энэ тухайгаа мэдэгдэн эмчилгээ хийлгүүлэх арга хэмжээ авч өгөхийг шаардах ёстой.

◆ Хоригдож байгаа хүн ч гэсэн хамгийн наад захын төвшинд гадаад орчинтой холбоо харилцаатай байхыг нь таслах явдал зүйд нийцэхгүй. Өнөөгийн хуулинд хорих байгууламжийн даргаас зөвшөөрөл авсан тохиолдолд захиалдалаар харилцаж болох талаар заасан байдаг. Зарим тохиолдолд хорих байгууламжийн дарга захидлаар харилцахыг зөвшөөрдөггүй бөгөөд ер нь ямар ч аргагүй болсон үед юм уу хамгийн наад захын төвшинд л захидлаар харилцахыг нь хязгаарлаж болно.

◆ Хорих байгууламжийн дотор хоригдол ном, сонин унших эрхтэй. Хорих байгууламжийн дарга хоригдол өөрийн мөнгөөр ном, сонин авч уншихыг хүссэн тохиолдолд аюул гарах магадлал байхгүй гэж үзвэл энэ шаардлагыг хүлээн авах ёстой.

◆ Ял эдлэгч өмгөөлөгчийн туслалцаа авах хэрэгтэй болсонтой холбогдуулан өмгөөлөгчтэйгээ холбоо барих өргөдөл гаргасан үед онцгой учир шалтгаан байхгүй бол хорих байгууламжийн дарга үүнийг хүлээж авах ёстой.

1-5. Гадаад иргэдийг хамгаалах газарт хоригдсон үедээ

◆ Гадаад иргэдийг хамгаалах газар нь Солонгост хууль бусаар оршин суудаг гэсэн шалтгаанаар Иммигрэйшиний ажилтанд баригдах юм уу гэмт хэрэг үйлдээд эх орондоо албан хүчээр буцаагдаж байгаа гадаадын иргэдийн байрладаг газар болно.

◆ Солонгосын иммигрэйшиний ажилтан "хамгаалалтад авах тушаал"-ын дагуу гадаадын иргэдийг Сөүл болон Хуасонд байдаг гадаад иргэдийн хамгаалах газарт байрлуулан хамгаална.

◆ Энэ үед иммигрэйшиний ажилтан 3 хоногийн дотор тухайн гадаадын иргэний эхнэр/нөхөр, гэр бүл, хамаатан садан, өмгөөлөгч юм уу өөр холбогдсон хүнд хамгаалалтанд байх хугацаа, хамгаалалтанд байх газар болон учир шалтгааныг бичгээр мэдэгдэнэ.(Иммигрэйшиний хяналтын хуулийн 54-р зүйл анги)

◆ Гадаадын иргэд хамгаалалтанд байх хугацаандаа байцаалтанд ордог бөгөөд тухайн үед өгсөн мэдүүлэг сүүлд шийдвэр гарах үйл явцад гол материал болдог тул өөрт ашиггүй зүйлийг хэлэх шаардлага байхгүй.

◆ Хамгаалах газарт очсоны дараа тухайн гадаадын иргэн дээр хүчээр гаргах арга хэмжээ авагдах нь тодорхой болвол тэр талаар бичсэн мэдэгдэх бичгийг үзүүлэн гарын үсэг авах болно. Мэдэгдэх бичигт баривчилж байгаагийн учир, хүчээр гаргаж байгаагийн учир зэрэг бичээстэй байдаг. Хамгаалах газрын зүгээс гарын үсэг зур гэсэн үед тухайн бичгийн агуулгатай нэгд нэггүй уншиж танилцах ёстой. Хэрэв агуулгыг нь сайн ойлгохгүй бол тайлбарлаж өгөхийг шаардах ёстой.

◆ Хүчээр гаргах арга хэмжээний шийдвэр гарахад түүнд түтгэлзсэн байр суурьтай байгаа бол 7 хоногийн дотор түтгэлзсэн өргөдлөө гаргаж болно. Тиймээс хүчээр гаргах арга хэмжээг зүйд нийцэхгүй гэж үзвэл түтгэлзсэн өргөдлөө гаргахыг хүсэе.

◆ Хэрэв хамгаалах газарт байх хугацаанд зүй бусаар харьцагдсан гэж үзвэл хандах бичиг боловсруулан улсын хүний эрхийн хороо гэх мэт хүний эрхийн байгууллагад хандаж болно.

◆ Мөн эрх тэгш харьцах үүднээс орчуулагч юм уу өмгөөлөгч дуудаж өгөхийг шаардах ёстой.

◆ Гадаад иргэдийг хамгаалах газарт эргэлт авах бололцоотой. Тиймээс гадаад иргэдийн хамгаалах газарт байх үедээ найз нөхөд юм уу гэр бүлийн эргэлт авах өргөдөл гаргаж, хэрэгтэй эд зүйлсээ авч болно. Хэрэв эргэлтээр ирэх ямар ч хүн байхгүй бол дэмжлэг үзүүлэх байгууллагатай зөвшилцөнө үү.

1-5-1. Авах ёстой цалингийн асуудалыг шийдвэрлэж өгөхийг шаардана уу.

Хууль бус оршин суугч ч гэсэн өөрийнхөө хийсэн ажилд оногдох цалин хөлсөө шаардах эрхтэй. Солонгосын Хууль зүйн яам нь авах ёстой цалинтай гадаадын ажилчидын тухайд цалингийн асуудалыг нь шийдвэрлэн эх орон руу нь буцаах зарчмыг баримталж байгаа. Тиймээс авч чадаагүй цалин байвал Иммигрэйшинд мэдэгдэх ёстой. Хэрэв авах ёстой цалингаа авч чадаагүй нөхцөлд хүчээр эх орон руу буцаахыг оролдвол хүчтэй эсэргүүцэл илэрхийлж авах ёстой цалингаа авсны дараа эх орондоо буцах хэрэгтэй.

1-5-2. Хуулийн шат дамжлагаар дамжиж байгаа аж үйлдвэрийн ослын хохирогч нь чөлөөлөгдөнө.

Солонгосын Хууль зүйн яам аж үйлдвэрийн осолд орсон гадаадын иргэнийг аж үйлдвэрийн осолтой холбогдсон хуулийн шат дамжлага нь дуусах хүртэл эх оронд нь буцаахгүй байх зарчмыг баримталж байгаа. Тиймээс аж үйлдвэрийн осолд орон хуулийн шат дамжлагаар явж байгаа хүн энэ тухайгаа мэдэгдэнэ үү. Иммигрэйшиний ажилтанд аж үйлдвэрийн ослын хохирогч гэдгээ илэрхийлж чадахгүй бол дэмжлэг үзүүлдэг байгууллагатай холбоо барина уу. Дэмжлэг үзүүлэгч байгууллагын зүгээс тухайн хүн аж үйлдвэрийн осолд орсон хүн болохыг нь баталж өгвөл хамгаалах газраас суллагдана. Хэрэв аж үйлдвэрийн осолд орсон бөгөөд хуулийн шат дамжлагаар дамжиж байгаа бол үүнийг батлах баримтыг байнга үедээ авч явах нь зүйтэй.

1-6. Иргэний зарга үүсгэх тохиолдолд

1-6-1. Иргэний заргын шат дамжлага

◆ Иргэний зарга үүсгэхдээ зарга үүсгэх бичиг(со-жан)-ээ боловсруулаад холбогдох шүүхийн газарт гаргахад болно.

◆ Зарга үүсгэх бичигт гомдол гаргагч(вонгу/дуудаж байгаа хүн) болон хэрэгтэн(пигу/шүүхэд дуудагдаж байгаа хүн)-ий хаяг, нэр тодорхой бичигдсэн байх ёстой.

◆ Зарга үүсгэх бичиг гаргах үед бага хэмжээний зардал ордог. Баталгаажуулсан тэмдэг(ин-жи-дэ) болон дамжуулсны төлбөр(сун-дал-рюу) шаардагддаг бөгөөд баталгаажуулсан тэмдэг нь нэхэмжилж байгаа мөнгөний хэмжээнээс шалтгаалан өөр өөр байдаг. Баталгаажуулсан тэмдэг нь нэхэмжилсэн мөнгөний 5/1000 вонтой тэнцдэг бөгөөд дамжуулсаны төлбөр нь хамрагдах хүн(гомдол гаргагч,

хэрэгтэн)-ий тооноос хамарч өөр өөр байна.

◆ Шүүх үйл ажиллагаа явагдах: Зарга үүсгэх бичиг бүртгэлд орвол шүүх байгууллагаас гомдол мэдүүлэгч болон хэрэгтэнд шүүх байгууллага руу ир гэсэн шаардах бичиг явуулна. Гомдол мэдүүлэгч болон хэрэгтэн шүүхийн газар дээр ирэн өөрийн баталж байгаа зүйлээ яриад, холбогдох баримт нотолгоог үлдээвэл шүүгч хоёр талын ярьсан зүйл болно үлдээсэн баримт нотолгоон дээр үндэслэн шүүхийн шийдвэр гаргана. Шүүгчийн шийдвэрийг түтгэлзэвэл давж заалдах эрхтэй. Давж заалдаад гарсан шүүхийн шийдвэрийг түтгэлзэвэл дээд байгууллагад дахин давж заалдаж болно. Ингэхэд зарцуулагдах хугацаа хэргийн агуулгаас шалтгаалаад янз янз байх хэдий ч ерөнхийдөө 1 жил шаардагддаг.

◆ Иргэний заргыг хувь хүн өөрөө үүсгэж болох хэдий ч гадаадын иргэн биечилэн хэрэгжүүлэхэд хүндрэлтэйн дээр Солонгос хэл дээр бичиг баримтаа бүрдүүлэх ёстой байдаг тул өмгөөлөгч хөлслөх нь зүйтэй.

1-6-2. Хүчээр хэрэгжүүлэх(Кан-жэ жиб-хэн)

◆ Иргэнийн зарга үүсгэснээр шүүхэд хандсан зорилго нь заавал биелэгдэнэ гэх баталгаа байхгүй. Хэрэв хэрэгтэн шүүхийн шийдвэрийг хэрэгсэхгүй бол шүүхийн шийдвэр хэрэгжүүлэх тасаг(шүүхийн шийдвэрийг хүчээр хэрэгжүүлдэг) дээр шүүхийн шийдвэрийг барьж очоод "хүчээр хэрэгжүүлэх өргөдөл" гаргасны дараа хэрэгжүүлэгчийн хамт хэрэгтэний эд хөрөнгийг хураан авч болно. Хүчээр хэрэгжүүлэх өргөдөл гаргахад нэмэлт зардал ордоггүй. Мөн хэрэгтэн эд хөрөнгөтэй эсэхийг урьдчилан мэдсэн байх нь зүйтэй.

◆ Хүчээр хэрэгжүүлэх өргөдөл гарган хэрэгтэний эд хөрөнгийг хураасан хэдий ч хэрэгтэн шүүхийн шийдвэрийг хэрэгсэхгүй байвал хураагдсан эд хөрөнгөнөөс нь дуудлага худалдаагаар зарж болно. Гэхдээ дуудлага худалдаанд оруулахад зардал орохын дээр цаг ч бас шаардагдана.

1-6-3. Нэхэмжилсэн мөнгөний хэмжээ 20сая–с доош хэмжээтэй байх үед

◆ Нэхэмжилсэн мөнгөний хэмжээ(20сая–с доош) их биш байх үед бага хэмжээний мөнгөний шүүх үйл ажиллагаа(су–эг шим–пан) явуулж өгөхийг шаардаж болно.

◆ Бага хэмжээний мөнгөний шүүх ажиллагаа нь зардал бага ордогийн зэрэгцээ 2 сар орчим болоход шүүх ажиллагаа нь дуусдаг тул авах ёстой цалингаа нэхэмжилэх үед их хэрэглэгддэг. Харин цалинг олгох ёстой ажил эрхлүүлэгч уг өргөдөлд түтгэлзсэн хариу өгвөл хугацаа сунжирдаг.

◆ Шүүх байгууллага дээр бага хэмжээний мөнгөний шүүх ажиллагаа явуулдаг газар бий. Энэ цаасыг бөглөөд өгөхөд болно. Хэрэв Солонгос хэл сайн мэдэхгүйгээс шүүх ажиллагаа явуулдаг газарт хэрэгтэй зүйлээ бичиж чадахгүй тохиолдолд шүүхийн ажилтанаас гуйж үнэгүй бичүүлж болно.

◆ Төлөх тушаалын өргөдөл(Жи–гөб мён–рён шинчон): Төлөх тушаалын өргөдөл нь шүүх ажиллагааны албан ёсны шат дамжлагад багтдаггүй ч зардал бага ордогын дээр амархан дуусдаг тул авах ёстой цалингаа нэхэмжилэх үед их хэрэглэгддэг. Төлөх тушаалын өргөдөл нь гол төлөв 2 сарын хугацаа шаарддаг бөгөөд хэрэгтэн

түтгэлзсэн өргөдөл гаргавал хугацаа бүр илүү сунжирч болно.

1-6-4. Иргэний зарга үүсгэх үедээ анхаарах зүйлс

◆ Иргэний зарга үүсгэе гэж байгаа бол эхлээд хэрэгтэнтэй холбоотой мэдээлэлтэй байх хэрэгтэй. Хэрэгтэний нэр, хаяг, хэрэгтэн хувь хүн биш компани байх тохиолдолд компаний нэр, хаяг зэргийг мэдэх шаардлагатай.

◆ Өөрийнхөө батлан хэлэх зүйлийг нотолж өгөх баримтыг бэлтгэх ёстой. Иргэний заргын үед шүүхэд дуудсан хүн өөрийнхөө батлан хэлж байгаа зүйлийг үнэн зөв гэдгийг нотлох ёстой.

◆ Хэрэв авах ёстой цалингаа авч чадаагүйгээс иргэний зарга үүсгэж байгаа бол ажил эрхлүүлэгчийн эд хөрөнгийн байдлыг мэдсэн байх шаардлагатай. Шүүхээр заргалдаад яллаа ч ажил эрхлүүлэгчид эд хөрөнгө байхгүй бол юу ч авч чадахгүйд хүрч ч болно.

◆ Авах ёстой цалингийнхаа асуудалаар Хөдөлмөрийн яаманд хандсаны дараа "төлөх тушаал"-ыг нэхэмжилэх юм уу "бага хэмжээний мөнгөний шүүх үйл ажиллагаа"-г явуулах үедээ Хөдөлмөрийн яам(ну-дун-бү)-аас "Авах ёстой цалинг баталгаажуулсан баримт(чэ-бүл хуаг-ин-вон)" авчирвал шүүх ажиллагаа улам хялбар болно. "Авах ёстой цалинг баталгаажуулсан баримт" нь ажил эрхлүүлэгчийн олгох ёстой цалинг Хөдөлмөрийн яамнаас тодруулж өгдөг баримт бөгөөд энэ байвал шүүх ажиллагааны явцад цалин олгох ёстой эсэхийг нь тусад нь шалгаж үздэггүй. Тиймээс шүүх ажиллагааг хялбарчилж өгдөг.

◆ Иргэний зарга үүсгэхэд хувь хүний паспорт хэрэгтэй.

◆ Иргэний зарга үүсгэхийн өмнө ажил эрхлүүлэгчийн үйлдвэр юм уу гэр нүүсэн эсэхийг тодруулах шаардлагатай. Хэрэв компани хуулийн этгээд бол бүртгэлийн газар(дөн–ги–су) дээр очин хуулийн этгээдийн бүртгэлийн хуулбарыг аваад, шүүхийн байгууллагад өгч байгаа бичиг баримтандаа хавсаргах ёстой.

◆ Иргэний зарга нь Хөдөлмөрийн яаманд гомдол мэдүүлэхтэй их өөр. Шүүх дээр очих ёстой өдрөө утсаар ярьж өөрчилж өгөхийг хүсч болохгүй. Мөн гомдол мэдүүлэгч юм уу хэрэгтэн 2–ын аль нэг нь шүүх дээр дуудагдсан өдрөө очихгүй бол аль очсон талынх нь өгсөн мэдүүлэгийг дагадаг тул дуудагдсан өдрөө очихгүй бол өөрт хохиролтой шүүхийн шийдвэр гарах магадлал өндөр.

◆ Шүүх хурлын үед шүүгчийн асуултанд хариулахгүй бол хэрэгтэний батлан хэлсэн зүйлийг дагах тул мэдэхгүй гэж хариулбал үгүйсгэж байна гэж хүлээн авна. Иргэний зарга үүсгэх үед өөрийнхөө байр суурийг тодорхой илэрхийлэх ёстой.

◆ Иргэний зарга үүсгэх болвол хэрэгжих шат дамжлагыг нарийвчлан авч үзэхийн дээр шүүх газрын зааврыг чандлан сахих ёстой.

2. Бэлгийн хүчирхийлэл, гэр бүлийн хүчирхийлэлийн хохирогчид үзүүлэх дэмжлэгийн систем

2-1. Бэлгийн хүчирхийлэл

◆ Бэлгийн хүчирхийлэл нь нийгэм дэх мэдэл, чадлын харилцаан дахь(нийгмийн байр суурь юм уу хүйс) хүчтэй нь хүчгүйдээ үзүүлдэг хүчирхийлэлийг хэлнэ.

◆ Бэлгийн хүчирхийлэл гэж хүчиндэх, хүчиндэхийг оролдох, хүчиндэх гэж дайрч довтлох, үг хэлээрээ дамжуулан бэлгийн харьцаанд орохыг хүчлэх зэргийг хэлнэ.

◆ Бэлгийн хүчирхийлэл гэж хохирогчийн бодол санааг үл хэрэгсэн хохироогч бэлгийн үйлдэл хийсэн тохиолдолыг хэлнэ. Өнөө үед бэлгийн хүчирхийлэл бага сагаар нэмэгдсээр байгаагийн зэрэгцээ бүлэглэж хүчиндэх тохиолдол ч өссөөр байгаа болно. Мөн хохирогчийн дотор хохирогчтой танил хүмүүс байх нь ч бий.

◆ Бэлгийн хүчирхийлэл нь хохирогчид бие махбодь, оюун санааны олон асуудал бий болгодог гэмт хэрэг болно. Хохироогчид хуулийн дагуу шийтгэл оногдоно. Тэд нийгмийн шүүмжлэлд өртсөнөөр нийгмийн амьдралд нь саад бэрхшээл их үүсдэг.

2-2. Ажлын газар дээр бэлгийн харьцаанд уру татах

◆ Ажлын газар дээр ажил эрхлүүлэгч, дээд албан тушаалтан аль эсвэл ажилчин байр сууриа ашиглах юм уу ажилтайгаа холбогдуулан

бусад ажилчиддаа бэлгийн холбогдолтой үг хэлэх, үйлдэл хийх гэх мэтээр бэлгийн доромжлол, бэлгийн дарамтанд оруулсан бол ажлын газар дээрхи бэлгийн уруу таталт болно. Мөн бэлгийн холбогдолтой үг болон үйл хөдлөлд таагүй хариулт өгснөөс болж ажил эрхлэлтэндээ хохирол амсах нь бэлгийн уруу таталтад орно.(Эрэгтэй хүн, эмэгтэй хүний ажил эрхлэлтийн тэгш эрхийн хуулийн 2–р зүйл анги)

◆ Хэн нэгийг онцгойлсон бэлгийн уруу таталт биш ч гэсэн ажлын газрын уур амьсгалыг бэлгийн таагүй орчноор солисон тохиолдол ч бэлгийн уруу таталтад орно.

◆ Ажлын газар дээр гардаг бэлгийн уруу таталтын тухайд Солонгосын хууль хатуу чанга шийтгэл оноодог.

◆ Ажлын газар дахь бэлгийн уруу таталт гэж зөвхөн эрэгтэй хүн эмэгтэй хүнд гаргадаг үйлдэлийг хэлдэггүй. Эмэгтэй хүн эрэгтэй хүнд гаргадаг үйлдэл ч бас бэлгийн уруу таталтанд ордог.

2-3. Ажлын газар дээрхи бэлгийн уруу таталтын хэлбэр

Ажлын газар дээрхи бэлгийн уруу таталт нь нийт 3 янзын хэлбэртэй)

◇ Бие махбодиор дамжсан үйлдэл

▶ Үнсэх, тэврэх, араас тэврэх гэх мэтийн бие махбодиор хүрэх үйлдэл

▶ Цээж, өгзөг гэх мэтийн биеийн онцгой хэсгийг илэх үйлдэл

▶ Массаж хийхийг шаардах үйлдэл

◇ Үг хэлээр дамжсан үйлдэл

- ▶ Секс шог хошин яриа, садар самуун шалиг завхай яриа
- ▶ Гадаад төрхийг бэлгийн асуудалтай холбон ярих
- ▶ Бэлгийн харьцааны талаар тасралтгүй асуух, бэлгийн харьцаатай холбоотой мэдээлэлийг санаатайгаар тараах үйлдэл
- ▶ Бэлгийн харьцааг хүчилсэн эсвэл өдөөсөн үйлдэл
- ▶ Хамт олноороо хоолонд орох(хвэ–шиг) үед архи хундгалахыг шаардах

◇ Нүд, харцаар дамжсан үйлдэл

- ▶ Порно зураг, хошин зураг, порно сэдэвтэй юм эрээчсэн цаас, сэтгүүл зэргийг хадах, үзүүлэх
- ▶ Шууд эсвэл факс, компьютер зэргээр дамжуулан садар самуун захиа, зураг, фото зураг явуулах
- ▶ Бэлэгтэй холбоотой өөрийн биеийн хэсгийг зориудаар ил гаргах, илэх үйлдэл

◆ Үүнээс гадна нийгэмд бэлгийн доромжлол, бэлгийн дарамт үзүүлдэг гэж хүлээн зөвшөөрөгддөг хэл яриа, үйл хөдлөлийн бусад хэлбэрүүд ч бэлгийн уруу таталтад хамаарагдана.

2-4. Ажлын газар дээрээ бэлгийн уруу таталтад орсон үед

◆ "Үгүй" гэж тодорхой хэл!

☞ "Үгүй" гэдэг үгээ тодорхой, баттайгаар, инээхгүйгээр хэлэх ёстой. Тэгэхгүй бол хохироогч буруугаар ойлгож ч болно.

◆ Ойр орчиныхоо хүмүүст энэ талаар ярь!

☞ Найз нөхөд, хамт ажилладаг хүмүүстээ хэлж туслалцаа ав. Энэ асуудлаар тэдэнтэй ярьж цаашид ийм асуудал гаргахгүйгээр

урьдчилан сэргийлж болно.

◆ Даргадаа мэдэгд!

☞ Ажил эрхлүүлэгч ажлын газар дахь бэлгийн уруу таталтыг урьдчилан сэргийлэх арга хэмжээ авах хуулиар хүлээсэн үүрэгтэй.

◆ Үйлдвэрчиний Эвлэл дээр оч!

☞ Үйлдвэрчиний Эвлэлийн зүгээс ажил эрхлүүлэгч нарт хандж хохироогчид шийтгэл өгөхийг шаардах юм уу өөр хэсэг рүү шилжүүлэхийг шаардан дахиж ийм явдал гаргахгүйн тулд эрэгтэй ажилчиддаа сургалт явуулах хэрэгтэй гэх мэтийн шаардлагыг тавина.

◆ Хуулийн шийтгэл шаардах хэрэгтэй!

☞ Ажлын газар дээрээ бэлгийн уруу таталтад орсон тохиолдолд Эмэгтэйчүүдийн яам юм уу Хөдөлмөрийн яаманд хандаж болно. Ажил эрхлэлтийн тэгш эрхийн хороо юм уу Эр эмээр ялгаварлан гадуурхах явдалыг хариуцсан хорооноос туслалцаа хүсэх арга ч бий. Мөрдөн байцаагчид заалдах, илчлэх маягаар эрүүгийн шийтгэл оногдуулж ч болно.

◆ Дэмжлэг үзүүлдэг байгууллага дээр оч!

☞ Бэлгийн уруу таталт үргэлжилсээр, ноцтой шатанд орвол дэмжлэг үзүүлдэг байгууллага дээр очиж туслалцаа хүсэх нь зүйтэй.

2-5. Бэлгийн уруу таталтын талаар буруу ойлголттой байх

◆ Бэлгийн уруу таталт нь хөнгөхөн тоглоом шоглоомын зүйл.

☞ Бэлгийн уруу таталт нь хохирогчийн амьдралын хүсэл зоригийг мохоож сэтгэл санааны дарамтад оруулдаг зүйл болно.

◆ Бэлгийн уруу таталт нь хувь хүний асуудал.

☞ Эрх мэдлийн харилцаанаас үүсдэг бэлгийн уруу таталт нь нийгмийн асуудал болно.

◆ ☞ Хохирогч хүсэхгүй байхад хохирогчид сэтгэл санааны ноцтой дарамт өгөх нь гэмт хэрэг үйлдэж байгаатай адил болно.

◆ Эрэгтэй хүн бэлгийн уруу таталтын хохирогч болно гэж үгүй.

☞ Бэлгийн уруу таталтын хохирогч нь зөвхөн эмэгтэй хүн байх албагүй. Эмэгтэй хүн эрэгтэй хүнд үзүүлдэг бэлгийн уруу таталт ч бас орно.

◆ Бие махбодиор хүрээгүй бол бэлгийн уруу таталтанд тооцогддоггүй.

☞ Хэл яриа, уур амьсгалаар бэлгийн уруу таталтанд оруулах нь ч үүнд багтана.

◆ Онцгой нэг хүнтэй холбоотой байжиг л бэлгийн уруу таталт болно.

☞ Ажлын газар дээрээ тодорхой бус тооны хүмүүсийг таагүй байдалд оруулдаг бэлгийн холбогдолтой хэл яриа, үйл хөдлөл юм уу ажлын уур амьсгалыг таагүй болгодог зүйл ч бас бэлгийн уруу таталтанд орно.

2-6. Хүчиндүүлсэн үед

◆ Хүчиндэх гэж хохироогч хохирогчийн санаа бодлыг үл хайхран хүчээр бэлгийн харьцаа хийхийг хэлнэ.

◆ Хүчиндүүлсэн эмэгтэй оюун санааны хувьд ноцтой шоконд орох төдийгүй бие махбодийн хувьд ч шархтах тохиолдолд их байдгаас энэ нь эмэгтэй хүнд олон янзын асуудалыг үүсгэдэг гэмт хэрэг болно.

◆ Хүчиндэх гэж заавал таньж мэдэхгүй хүний хийдэг үйлдэл биш бөгөөд таньж мэддэг хүн үйлдэх нь ч бий.

◆ Хүчиндүүлсэн үедээ

▶ Юун түрүүнд эмнэлэг явна

▶ Хувцасаа ялангуяа дотуур хувцасаа хаях юм уу биеэ угааж болохгүй.

▶ Цагдаагийн газар юм уу ойр орчны хүн, зөвлөгөө дэмжлэг үзүүлдэг төв дээр очиж туслалцаа гуйна.

▶ Хохироогчид шийтгэл хүлээлгээ гэсэн үедээ эмчийн магадлагааны бичиг болон заалдах бичгийг гарган цагдаагийн газарт заалдах ёстой.

◆ Өөрийн чинь буруугаас болсон гэж бодож огт болохгүй.

Хүчинд өртсөн эмэгтэйчүүд нь гэмт хэргээс болж хохирсон хохирогчтой адил. Гэвч зарим тохиолдолд гэр бүл, нийгмийн зүгээс "Биеэ зөв авч явж чаддаггүй эмэгтэй" гэх юм уу "Бие биендээ таалагдаад бэлгийн харьцаанд орсон" гэх мэтийн шүүмжлэл, буруу ойлголтонд өртөж болно. Эргэн тойрны энэ мэт байдал нь хохирогч эмэгтэйг бүр хэцүү байдалд оруулдаг. Гэмт хэргийн улмаас хохирсон эмэгтэй халуун дотно халамжинд байх ёстой. Мөн харамсалтайгаар хүчиндүүлсэн эмэгтэй өөрийн буруугаас болж ийм байдалд орсон гэж огтхон ч бодож болохгүй.

2-7. Гэр бүлийн хүчирхийлэл

◆ Гэр бүлийн хүчирхийлэл нь аар саар гэр бүлийн хүрээний асуудал

биш. Ялангуяа эхнэртээ харгис хэрцгий хандах нь нийгмийн асуудал бөгөөд ноцтой гэмт хэрэг болно.

◆ Солонгост ч бас сүүлийн хэдэн жилийн дотор гэр бүлийн хүчирхийлэлтэй холбогдсон асуудал хөндөгдөх болсон болно. Гадаадын ажилчидын гэр бүл, солонгос хүнтэй суусан гадаадын ажилчины гэр бүлд гэр бүлийн хүчирхийлэл гарч, ноцтой асуудал болсоор байгаа билээ.

◆ Гэр бүлийнхэндээ хүч хэрэглэдэг эрэгтэйчүүдийн дийлэнхи нь оюун санаа, сэтгэл мэдрэлийн асуудалтай хүмүүс байдаг гэж ойлгож болно.

◆ Эхнэртээ харгис хэрцгий ханддагийн учир шалтгаан нь эрэгтэй хүн давуу эрхтэй гэсэн ухамсар, өсөж торнисон орчин, зан араншингийн доголдол, гэр бүлийн зохистой харилцааг хадгалах арга барилын дутагдал, эр нөхрийн архиний муу зуршил, эр нөхрийн хардалт, ухамсарын доод төвшин зэрэг болно.

◆ Гэр бүлийн хүчирхийлэлийн ихэнх нь аажим аажмаар ноцтой болдог бөгөөд даамжирч зуршил болох нь ч бий. Мөн үр хүүхдэд муугаар нөлөөлдөг тул үр хүүхдийнхээ төлөө ч болтугай гэр бүлийн хүчирхийлэлийг зүгээр өнгөрөөж болохгүй.

◆ Эхнэр нөхрийн хооронд зөрчил үүссэн үед харилцан ярилцан асуудалаа шийдэх оролдлого чармайлтыг ердийн үед хийх ёстой.

◆ Эхнэр нөхөр хоёр хоорондоо ярилцан гэр бүлийн хүчирхийлэлийг таслан зогсоож чадахгүй тохиолдолд зөвлөгөө өгөх газарт очиж туслалцаа гуйх шаардлагатай.

◆ Өөрийн чинь ойр орчинд гэр бүлийн хүчирхийлэл явагдаж байхыг харвал тэр даруйдаа цагдаагийн газарт очиж мэдэгдэх юм уу зөвлөгөө өгөх газар руу холбоо барьж тусламж хүснэ үү!

◆ Нөхөр чинь зодохыг завдсан үед тухайн газраас зугатаж гарч ирэх юм уу цагдаагийн газар, эмэгтэйчүүдийн яаралтай дуудлага хүлээж авдаг газар руу ярих нь зүйтэй.

◆ Эр нөхрийнхөө хүчирхийлэлээс зугтан гарч ирсэн үедээ зөвлөмж өгөх газар руу очин, аль эсвэл утасдан тусламж хүснэ үү. Солонгост ийм тохиолдолд эмэгтэйчүүд очиж байрлах зориулалттай дэмжлэг үзүүлдэг байгууллагууд бий.

2-8. Хохирогчид зориулсан дэмжлэгийн систем

Солонгост бэлгийн уруу таталт, хүчинд өртсөн юм уу нөхрийнхөө хүчирхийлэлээс зугатан гарч ирсэн эмэгтэйчүүдэд туслалцаа үзүүлдэг байгууллага олон байдаг. Хэрэв харамсалтайгаар ийм үйлдэлд өртөх юм уу, ойр орчимдоо ийм юм болж байхыг харв[᠙] эдгээр байгууллагууд руу холбоо барьж өгнө үү.

◆ Бэлгийн хүчирхийлэл болон гэр бүлийн хүчирхийлэлийн үед зөвлөгөө өгөх газрууд

▶ Бэлгийн хүчирхийлэл болон гэр бүлийн хүчирхийлэлтэй холбогдсон мэдээлэл авна.

▶ Зөвлөгөө өгнө.

▶ Хамгаалалт хэрэгтэй үед түр хамгаална.

- ▶ Хуулиар асуудалаа шийдвэрлэхэд нь туслана.
- ▶ Хүчирхийлэлд өртсөн эмэгтэйчүүдэд шуурхай эмчилгээгээр дэмжлэг үзүүлдэг төв байдаг тул хэрэгтэй үед төрөл бүрийн програмд үнэгүй хамрагдаж болно

◆ Эмэгтэйчүүдийн яаралтай утас: 1366

- ▶ Хохирогч эмэгтэйчүүдэд зориулсан эмэгтэйчүүдийн яаралтай утас болно.
- ▶ Хамгийн ойрхон зөвлөгөө өгөх газартай холбогдож өгнө.
- ▶ Зөвлөгөө өгөх газар, эмчилгээний байгууллага, хамгаалалтын байгууламж зэрэгтэй танилцуулж өгнө.
- ▶ 365 өдөр 24 цагийн турш зөвлөгөө өгч, шуурхай хамгаалалтанд орж орж болно.
- ▶ Тахир дутуу эмэгтэйчүүд ч бас хамрагдана.

◆ Гадаадын ажилчидын хүний эрхийг хамгаалах утас: 1588–1138

- ▶ Гадаадын ажилчидад зориулсан зөвлөгөө өгөх утас болно.
- ▶ Хамгийн ойрхон гадаадын ажилчидад зөвлөгөө өгөх газартай холбож өгнө.
- ▶ Үдээс өмнө 10 цагаас үдээс хойш 6 цаг хүртэл боломжтой.
- ▶ Ням гаригт ч бас зөвлөгөө авч болно.(Даваа–Ням 10–18цаг)

3.Өдөр тутмын амьдралтай холбогдсон мэдээлэл

3-1. Солонгосын эмнэлэгийн тогтолцоо

◆ Солонгосын эмнэлэгийн систем нь 1, 2, 3–р шатанд хуваагддаг бөгөөд шат дамжлагатайгаар эмчилгээний байгууллагыг ашиглуулдаг тогтолцоотой. Юуны өмнө бие өвдсөн тохиолдолд хувийн эмнэлэг болох 1–р шатны эмнэлэг дээр очино. Мөн нэгдсэн эмнэлэг болох 2, 3–р шатны эмнэлэг дээр очъё гэвэл 1–р шатны эмнэлэгийн эмчийн магадлагаатай байх шаардлагатай.

◆ Орон нутаг бүрт улсаас ажиллуулдаг эрүүлийг хамгаалах газар байдаг. Эрүүлийг хамгаалах газар нь хүнд биш өвчинийг эмчилж өгдөгөөс гадна үнэгүй байдаг.

◆ Эмчилгээ хийлгэх шаардлагатай хэдий ч мөнгө байхгүй хүмүүст үнэгүй эмчилгээ хийж өгдөг газар ч бий. Өвчиний оношийг тогтоож өгөхөөс гадна зарим нэг эмийг үнэгүй олгоно.

◆ Эрүүлийг хамгаалах газар юм уу үнэгүй эмчилгээний газарт очъё гэвэл энэ талаархи мэдээлэлийг гадаадын иргэд дэмжлэг үзүүлдэг байгууллагад хандан асууж болно.

3-2. Эрүүл мэндийн даатгалын тухайд

◆ Аж үйлдвэрийн дадлагажигч гадаадын иргэн болон ажил

эрхлэлтийг зөвшөөрсөн системээр ирж ажиллаж байгаа гадаадын ажилчид эрүүл мэндийн даатгалд хамрагддаг тул компаниасаа "Эрүүл мэндийн даатгалын карт"-ыг авч эмнэлэг явахдаа авч явна. Харин хууль бус ажилчид эрүүл мэндийн даатгалд хамрагддаггүйн улмаас өндөр үнэтэй эмнэлэгийн төлбөр төлж эмчилгээ хийлгэхээс өөр арга байдаггүй. Иймэрхүү хүндрэлтэй асуудалыг нь хөнгөвчилж өгөхийн тулд гадаадын ажилчидад дэмжлэг үзүүлдэг байгууллагууд эмнэлэгүүдтэй хамтарч "Гадаадын ажилчидын эмчилгээний төлбөрийг хөнгөлөх зөвлөл" гэсэн сүлжээ байгуулан ажиллуулж байгаа болно.

◆ "Гадаадын ажилчидын эмчилгээний төлбөрийг хөнгөлөх зөвлөл"-д гишүүнээр элсвэл 1-р шатны эмнэлэгт нийт эмчилгээний төлбөрийн 30-40 хувь, 2 болон 3-р шатны эмнэлэгт 40-50 хувийн хөнгөлөлттэйгээр эмчилгээ авч болно. "Гадаадын ажилчидын эмчилгээний төлбөрийг хөнгөлөх зөвлөл"-д элсээд 3 сар болвол хөнгөлөлт үзүүлсэн эмнэлэгийн эмчилгээний төлбөрийн тодорхой хэсгийг гаргаж өгнө.

◆ "Гадаадын ажилчидын эмчилгээний төлбөрийг хөнгөлөх зөвлөл"-д элсэн орьё гэвэл гишүүнд элсэх хураамж 5,000вон болно. Эхний сарын гишүүний төлбөр болох 6,000вон, 2 хувь зураг, паспортын хуулбараа авчиран хамгийн ойрхон гадаадын иргэдэд дэмжлэг үзүүлдэг байгууллага дээр очно уу. Гишүүний хураамж 1 сарын 6,000вон болно.

◆ Эмчилгээний хөнгөлөлт гадаадын ажилчидын эмчилгээнд туслалцаа үзүүлдэг(тогтоогдсон) эмнэлэгүүдэд л үйлчлэх тул эмнэлэг

явахаасаа өмнө эмчилгээний төлбөрийг хөнгөлөх зөвлөл(орон нутаг дахь)–ийн зөвлөгөө өгөх газартай холбоо барьж, тийм эмнэлэгийн талаархи мэдээлэл авна.

3-3. Аптектэй холбогдуулаад

Солонгос нь эмийн ... Солонгост ихэнхи эмийг рецепттэй хүнд л худалддаг. Антибиотомуудыг зөвхөн рецепттэй хүнд л худалдах жишээтэй. Харин ханиадны эм, хоол шингээдэг эм, халуун буулгах эм, өвчин намдаагч зэргийг рецептгүйгээр худалдан авч болно.

3-4. Түргэн тусламж хэрэгтэй үед

Өвдөх юм уу аваар осолд орсны улмаас яаралтай эмнэлэгийн хүлээн авах тасагт очих шаардлагатай болсон үед 119 юм уу 129 рүү залгавал түргэний машин ирж, өвчтөнийг хүлээн авах тасагт хүргэж өгнө.

3-5. Зодуулах, автын осолд орсон үед

Солонгос хүн юм уу өөр орны хүнд зодуулах, автын осолд орох гэх мэтээр аваар осолд өртөгдөх үе байхийг үгүйсгэхгүй. Ийм тохиолдолд юуны өмнө зодуулсаны баримт нотолгоо юм уу автын осол гаргасан машины дугаар зэргийг олж мэдээд, улмаар дэмжлэг үзүүлдэг байгууллага дээр очин зөвшилцөхийг хүсье. Мөн ийм тохиолдолд эмчилгээний асуудал болон эмчилгээний зардал, хохироогчид оноох шийтгэл зэргийг давхар шийдэх ёстой байдгаас дэмжлэг үзүүлдэг байгууллагын туслалцааг авах нь зүйтэй.

3-6. Банкаар үйлчлүүлэх үедээ

◆ Паспорт юм уу паспортны хуулбар байвал аж үйлдвэрийн дадлагажигч болон хууль бус оршин суугч нь ердийн банкинд хадгаламжийн данс нээж болно. Хадгаламжийн дэвтэр нээх үедээ бэлэн мөнгөний картыг хамт авах хэрэгтэй. Учир нь бэлэн мөнгөний карт байвал бэлэн мөнгөний автомат машин(АТМ)-аас хэрэгцээтэй үедээ мөнгө авч болно гэсэн үг.

◆ Солонгосын банк нь автомажсан тул бэлэн мөнгөний автомат машин(АТМ)-ыг хэрэглэх аргыг сурсан байхад илүүдэхгүй. Банкинд хадгаламжийн дэвтэр нээснээр АТМ-аас мөнгө авах, өөрийнхөө дансанд мөнгө мөнгө хийх, хадгаламжийн дэвтэр юм уу бэлэн мөнгөний карт байхгүй тохиолдолд ч өөр хүнд мөнгө явуулах боломжтой болно.

◆ Бэлэн мөнгөний карт байхгүй үед хадгаламжийн дэвтрээ ашиглаж болно.

◆ Данс нээх үедээ нууц дугаараа банкинд хэлж бүртгүүлэх хэрэгтэй. Нууц дугаараа мэдэхгүй бол мөнгөө авч чадахгүй. Мөн өөрөөсөө өөр хэнд ч нууц дугаараа мэдэгдэж болохгүй. Данс нээх үед тусалсан хүндээ ч мэдэгдэж болохгүй. Яагаад гэвэл таны хадгаламжийн дэвтэр юм уу бэлэн мөнгөний картыг хулгайлсан, олсон хүн нууц дугаарыг чинь мэдэхгүй тохиолдолд таны мөнгөнд гар хүрч чадахгүй.

◆ Хадгаламжийн дэвтэр юм уу бэлэн мөнгөний картаа хаясан

тохиолдолд дансныхаа дугаарыг л мэдэж байхад паспорт юм уу паспортны хуулбараа авч очоод, өөрийнх чинь гэдгээ тогтоолгуулсаны дараа дахин дэвтэр нээж болно.

3-7. Байшин юм уу өрөө хөлслөх үедээ анхаарах зүйлс

◆ Компаниас олж өгсөн байранд амьдрахаасаа илүү өрөө хөлсөлж амьдардаг гадаадын иргэд олон байдаг. Солонгост байшин юм уу өрөөг их хэмжээний мөнгө барьцаанд өгч түрээслэх(жон-сэ) эсвэл сарын түрээс өгч түрээслэх(волсэ) боломжтой. Жонсэ гэдэг нь түрээсийн гэрээ байгуулах үедээ гэрийн эзэнд их хэмжээний мөнгө өгөөд түрээсийн гэрээ дуусч, байр суллах үедээ эргүүлэн авдаг түрээсийн хэлбэрийг хэлнэ. Волсэ гэдэг нь бага хэмжээний баталгааны мөнгө(бу-жөн-гөм)-ийг гэрийн эзэнд өгч сар бүр тодорхой хэмжээний түрээсийн төлбөр төлөхийг хэлнэ.

◆ Өрөө хөлслөх юм уу амьдарч байсан өрөөнөөсөө гарч өөр тийшээ нүүх үедээ таньдаг хүмүүсийнхээ туслалцааг авах юм уу эсвэл албан ёсны үл хөдлөх хөрөнгийн зуучилалын газар(буг-дог-бан)-с туслалцаа авч ч болно. Үл хөдлөх хөрөнгийн зуучлалын газраар дамжуулан өрөө хөлслөх болвол тухайн газарт бага хэмжээний төлбөр төлөх шаардлагатай.

◆ Гэр юм уу өрөө олох үедээ гэрээ байгуулагч гэрийн эзэн мөн эсэхийг бат тодруулсан байх ёстой. Үүний тулд бүртгэлийн газар(дөн-ги-су) дээр очин, хөлслөх гэж байгаа гэрийнхээ хаягаар гэрийн эзэн хэн болохыг тодруулах хэрэгтэй бөгөөд тодруулсан

зүйлээ хувилж авч ч болно. Хувь хүн хувилж авах өргөдөл гаргасан ч болно, аль эсвэл үл хөдлөх хөрөнгийн зуучлалын газраас хувилж өгөхийг хүсч ч болно. Гэрээ байгуулах үедээ гэрийн эзний иргэний үнэмлэх юм уу паспорт, жолооны үнэмлэх зэрэг гэрчлэх баримттай танилцан, гэрийн эзэн эсэхийг магадлах шаардлагатай.

3-8. Мөнгө зээлүүлэх юм уу зээлэх үедээ

◆ Найз нөхөд юм уу захирал, компаний хамаарагч гэх мэт танидаг хүмүүстээ мөнгө зээлүүлээд, тэд эргүүлж төлөхгүй зугатсанаас болж хохирол амсах тохиолдол олон. Энэ маягаар хохирол амсахгүйн тулд мөнгө зээлдэхдээ тухайн хүнийхээ итгэлтэй эсэх, мөнгөний асуудалтай эсэхийг нь заавал тодруулах ёстой. Мөн гэрээний бичиг юм уу төлбөрийн хуудасыг заавал авч үлдэх шаардлагатай. Хэрэв сэжигтэй хүнд яалт ч үгүй мөнгө зээлүүлэх болвол батлан даагч юм уу эд барааг барьцаанд авах хэрэгтэй.

◆ Мөрийтэй тоглоом гэх мэт буруу муу зүйлд хэрэглэх гэж байгааг нь мэдсээр байж мөнгө зээлүүлсэн хийгээд зээлсэн этгээд мөнгөө эргүүлж өгөхгүй тохиолдолд цагдаад хандах ч эрх байхгүй. Тиймээс буруу муу зүйлд зарцуулагдах мөнгийг зээлүүлэх ёсгүй.

◆ Мөнгө зээлэх үедээ гэрээний агуулгыг тодорхой мэдэж байх шаардлагатай. Сүүлд хэт өндөр зээлийн хүү төлөх ёстой байдалд орж ч болзошгүй.

◆ Зээлсэн мөнгөө эргүүлж төлсөн үедээ заавал төлбөрийн хуудас юм уу тангарагийн бичгээ буцааж авах ёстой. Эс тэгвэл дахин төлөх

байдалд орж ч магадгүй.

3-9. Авсан бараа чинь дефекттэй байх үед

◆ Солонгост амьдрах хугацаандаа авсан бараа тань дефекттэй байх тохиолдол мэр сэр бий. Энэ тохиолдолд бараа авсан дэлгүүр дээрээ очоод сольж өгөх юм уу бараа буцаахыг шаардаж болно. Хэрэв өөрийн чинь зүгээс ямар 1 буруу байхгүй бол ихэнхи тохиолдолд таны шаардалагыг хүлээж авна. Гэвч дэлгүүрээс авахад дефекттэй байсан барааг сольж өгөхгүй юм уу буцааж өгөхгүй байх тохиолдол ч бас бий. Энэ үед дэлгүүрийн эзэнд хүчтэй шаардлага тавьж үзээд хүлээж авахгүй бол хэрэглэгчидийн эрх ашиг хамгаалах газар руу утасдах хэрэгтэй. Хэрэглэгчидийн эрх ашгийг хамгаалдаг төлөөлөгч байгууллагуудын нэг нь Сөүл дэх Солонгосын хэрэглэгчидийн эрх ашгийг хамгаалах газар бөгөөд утасны дугаар нь (02)3460-3000 болно.